



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/379

Мандалговь

Багийн Засаг дарга нарт сургалт зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйл, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 318-р тушаалын 318.2.1.5 дахь заалт, 2019 оны Эдийн засаг, Нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэл ажлыг хангах, Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт, шинэчлэлтийг хийж гүйцэтгэх, багийн Засаг дарга нарын мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор Багийн Засаг дарга нар болон сумдын Статистик хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсугай.

Хоёр. Сургалтыг чанартай зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга (М.Цогзолмаа), Статистикийн хэлтсийн дарга (Б.Энхтуяа) нарт даалгасугай.

Гурав. Сургалтын зардал, хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Дөрөв. Дээрх сургалтын зардал 2,772,000 (Хоёр сая долоон зуун далан хоёр мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

488191071

Аймгийн Засаг даргын 2019 оны
10 дугаар сарын...-ны өдрийн 379 дугаар
захирамжийн хавсралт



БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН СУРГАЛТЫН ЗАРДАЛ

№	Зардал	Оролцогчдын тоо		Зохион байгуулагч		Нийт оролцогчид	Өдөр	Нэгж үнэ	Нийт үнэ
		Сумдын статистик хариуцсан мэргэжилтнүүд	БЗД нар	АЗДТГ	Статистикийн хэлтэс				
1	Өдрийн хоол	15	68	8	8	99	2	10,000	1,980,000
2	Цайны завсарлага							4,000	792,000
	Нийт дүн								2,772,000